ТАХЬ
эх нутагтаа эргэж ирсэн нь



Леопольд СЛОТТА БАХМАЕР-ийн өгүүлэг
Крис ЗАЛЬЦЕР, Петра КАЧЕНСКИ, Райнер РЕЗЕРС нарын зургууд

ТАХЬ
эх нутагтаа эргэж ирсэн нь



Орчуулагч: С.Оюунтуяа
Редактор: Б.Сор-Тана

Гадаа хүйтэн байлаа. Моторын дуу нэг л эвгүй чангаар хүнгэнэнэ. Тахь давчуу хайрцган дотор ихэд айж байв. Тэрээр Цюрих хотын ойролцоох ногоон зүлгэн дээрээс бусад эгч нарынхаа хамтаар хөөгдөж байгаад өчигдөрхөн баригдаж ирээд байгаа нь энэ. Тэгээд энэ эвгүй хайрцган дотор орчихсон юм. Тэр яг юу болсныг ч сайн санахгүй байлаа. Өчигдөр өглөө гэнэт маш олон танихгүй хүмүүс хашаанд цугласан байсан болохоор тахийн сүрэг нэг л сандруу байж. Дараа нь тахийг ямар нэгэн зүйлээр хатгахыг тэр мэдрэв. Шумуул юм болов уу гэж бодсон боловч шумуул гарах цаг арай болоогүй юм шиг. Тэгээд сэрээд хартал энэ хайрцганд байсан хэрэг.



Гэхдээ энэ явдлаас хойш даруй хэсэг хугацаа өнгөрчихсөн байна. Гэнэт нөгөө моторын чимээ өөрчлөгдөж, газар дайвалзаж эхлэхэд тэр дороо айхтар бүдчив.

Тэгснээ чимээ намдчихлаа.

Хаалганууд онгойж, хурц гэрэл тахийг гялбуулав.

Гадаа маш халуун, тоос шороотой байх агаад өөр амьтдын хурц үнэр хамар цоргино. Хайрцагнуудыг гадагш зөөж гаргахад тэнд маш олон хүн цугласан байхыг олж харлаа. Тэд өөр хоорондоо тахийн мэдэхгүй хэлээр ярилцаж байх юм. Тэнд байсан олон хүн тахийн ах дүүсээс өөр харагдах морь унасан байлаа.

Тэд алгаа ташицгааж, ойлгомжгүй хэлээр ямар нэг юм найрсгаар хэлнэ. Сэтгэл нь ихэд хөдөлсөн бололтой.

Тэдний дундаас нэг морьтой хүн хайрцагнууд руу дөхөж ирээд ихэнхи цагийн турш хайрцагны хажууд байсан хүнтэй ярилцлаа.

Тэр, "Говь нутгийн үндэсний паркт тавтай морилно уу! Монголын түүхийн салшгүй нэг хэсэг болох тахийн сүргийг эх нутагт нь эргүүлэн авчирсан та бүхэнд гүнээ талархая" гэж хэлэв.

Хэлсэн юм нь өөр утгатай байж болох ч үнэндээ тахийн хувьд хамаагүй байлаа. Тэр бүүр ядарч өлсөөд гагцхүү энэ муухай хайрцагнаас гарахыг л хүсч байсан юм.

Төд удалгүй хайрцаг онгойв. Түүнд ямар санагдсан бол? Бүх зүйл гэрээс нь огт өөр байлаа.

Шим шүүстэй ногоон зүлэг, том том моднууд, үргэлж ус

уудаг байсан цөөрөм нь хаана байна вэ?

Энд бүх зүйл гандуу бор өнгөтөй, зүлэг гэх юм бараг үгүй байв. Мод сөөг ерөөсөө байхгүй, усны бараа ч харагдахгүй байлаа. Маш хуурай, халуун бөгөөд зөөлөн салхи элс хуйлруулан салхилж байв. Юу болох нь энэ вэ? Хамаа алга, хамгийн гол нь арай гэж энэ хайрцагнаас гарч чадлаа.

Бусад хайрцагнуудаас гарч ирж байгаа тахьнуудаас таньдаг тахь нэг ч байсангүй.

Шинээр ирсэн тахьнууд ямартай ч хамт байх бололтой. Хөгшин гүүнүүдийн нэг нь сүргийг ахлахаар болов. Бүгд хамтдаа шинэ амьдрах орчин тойронтойгоо танилцлаа.

"Энд ядаж л биднийг хүмүүсээс хамгаалах сараалжин хашаа байгаа юм байна" гэж тахь бодлоо.



Тэнд бас хуучин нутгийнх нь малын хороог санагдуулах зүйл байв. Тэндээс сүрлийн үнэр гарж байлаа. Тэгэхээр идчихмээр юм байгаа бололтой. Ам нь улам их цангаж эхэллээ. Тахьнууд толгойгоо өргөөд, салхиар дамжин ирж байгаа усны үнэрийг авцгаав. Тэд хашааг усаар хангаж байгаа нэгэн жижиг гол руу сандран давхилаа.

Ингэж нэг уух юмны бараа харах гэж! Тэнд сэрүүхэн сайхан байх агаад шим шүүстэй зүлэг ногоотой байв. Даанч дэндүү эрт баярлажээ.

Цус сорогч шумуулын сүрэг тэдэн рүү дайрч эхлэхэд усаа аль болох хурдан уух хэрэгтэйгээ ойлгоцгоолоо. Голоос бага зэрэг зайдуу, салхи ихтэй газар бараадсан хойно л ялаа шумуул тэднийг тайван орхижээ. Энэхүү танилцах аялалын дараа тахь өвс зулгааж, холын аяллынхаа алжаалыг тайлж амарч авлаа.

Тахь сүргийнхээ бусад тахьнуудтай танилцаж эхлэв. Бараг л бүгд ерөөсөө унагалж байгаагүй залуу гүүнүүд болохыг мэдэж авчээ. Арай хөгшин ганцхан гүү байв.

Энэ гүү азаргатай хамт сүргээ толгойлох болов. Тэр хоёр сүргээ хашаан дотор ч, ус тэжээл эрэхэд ч толгойлон удирдах боллоо. Долоо хоног өнгөрөхөд тахийн сүрэгт өөр шинэ зүйл тохиолдсонгүй. Харин идэх өвс хаанаас олох, яаж амныхаа цангааг гаргах, түүгээр ч барахгүй цус сорогч ядаргаатай шумуулуудын учрыг ч олж сурчээ.

Ингээд цаашид өдөрт ганцхан удаа ус уудаг боллоо. Энэ нутагт бороо маш бага ордог байв. Тахь бага багаар Швецарийн цасанд дарагдсан уул нуруу, ногоон зүлэг, ой модоо санахаа болив.Нэг өдөр нөгөө сонин морьтой хүмүүс дахиад хашаанд ороод ирчихсэн байв. Ер нь хүмүүстэй маш болгоомжтой харьцах нь зөв.

Тэд ойртсоор л, улам ойртсоор байлаа. Тахийн сүрэг тэднээс аль болох зайтай байхыг хичээнэ.

Тэд аль хэдийн сараалжин хашаа хүртэл тулж ирсэн байв. Ингэхэд ямар сараалжин хашаа билээ? Хашаа хаана байна аа? Сараалжин хашаа нь ор сураггүй алга болсноор барахгүй урьд нь огт очиж үзэж байгаагүй шинэ газар хөөгдөөд ирчихсэн байв.

Тэр морьтой хүмүүс тахийн сүргийг өдөржингөө хөөж явжээ. Ингэж явах үнэхээр хэцүү байлаа. Олон тахь нэг цагийн дараагаас л ядарч туйлдаж эхэлжээ.

Энд нэг , тэнд нэг өвс зулгаах гэсээр яг сайхан тухтай идэх цаг үлдсэнгүй. Нар жаргаж эхлэхэд арай гэж морьтой хүмүүс явж, тахийн сүрэг огт танихгүй газарт эзэнгүй үлдэв. Тэд шинэ нутгийнхаа амьдралд дасаж чадахгүй байлаа.

Харин бүгд айснаасаа болоод хоорондоо шахцалдан зогсов. Ийнхүү нэг шөнийг өнгөрөөжээ. Нар мандах үед бүгд их өлссөн байлаа. Уг нь энд цадталаа идэж болохоор өвс хангалттай ургасан байв. Тэдний идсэн өргөстэй ургамлууд анхандаа бага зэрэг хачин амттай байлаа. Гэхдээ маш сайн зажилж идэх юм бол хангалттай цадаж болохоор байсан юм. Энд бас амны цангаагаа гаргаж болохоор худаг байв. Морьтой хүмүүс тэнд байсаар л байна.
Тэр хүмүүс хол зайтай байсан учир айх зүйлгүй байлаа.

Тэд хүмүүсээс болгоомтой байхыг сурчээ. Энд малын хашаа хороо огт харагдахгүй байгаад тахь гайхаж байв.

Тахийн сүрэг аажмаар шинэ нутагтаа дасаж эхлэв. Тэд ёл шувуу нисэхийг анх харж, тогоруу, сүүлт гөрөөстэй тааралдаж, урт чихтэй, урт сүүлтэй инээдтэй жижигхэн амьтад зүлгэн дээр үсэрч харайж байхыг ажиглалаа. Мөн анх удаагаа уулан дээр тэх байхыг харж, тэдний гайхалтай авирах чадварыг биширлээ.





Өргөн тал дундуур хажуугаар нь олон зуун хулан давхиж өнгөрдөг байв. Тэд өөр олон ус уух газар байдгийг олж мэдэв.

Тэнд хааяа хонь, ямаа, морь, тэмээгээ тал дундуур хариулж, худгаас ус уулгаж байгаа хүмүүстэй тааралдана.

Шөнө дунд хэсэг чоно тахийн сүрэг рүү дайрах аюултай байлаа. Европт байхдаа нохойг л мэддэг байсан юм. Гэхдээ нохой үргэлж хашааны цаана байдаг байсан болохоор аюулгүй байв. Харин чоно их аюултай ажээ. Тэд бие биерүүгээ шахаж зогсоод хойд хөлөөрөө тийрнэ. Энэ үед чоно аюулд орж эргэж зугтаана.

Азаар тахийн сүрэг дотор унага байсангүй. Хэрэв байсан бол илүү их анхааралтай байх шаардлагатай юм. Өдөр богиносох тусам тахь өөр ямар ч тахийн сүргийг олж харахгүй байгаагаа их л гайхна. Үүний хариултыг нэгэн хулангаас олж сонсов. Тэр бол говьд амьдардаг илжиг билээ. Урьд нь говьд маш олон хулантай тааруч байсан боловч тэд тахийн сүрэгтэй бараг юм ярьдаггүй байв. Харин энэ хулан нэг л өөр байлаа. Тэр сүрэгрүү ойртож ирээд тахьд ингэж хэлэв:

—Би та нар шиг ийм адууг урд өмнө нь энд харж байгаагүй юм байна.

—Та нар шиг адуу гэж юу гэсэн үг вэ?

—Яахавдээ, та нар шиг хүнээр маллуулдаггүй адууг л байхгүй юу. Бидний өвөг эцэг говьд хар дэлтэй хүрэн адуу байдаг байсан гэж дээр үед ярьдаг байсан. Хүмүүс тэр үед энэ хавьд их хэмжээний ямаа, хонь, адуу авчирсан болохоор өвс ногоо улам ховордсон. Тэр үед хулан бидэнд маш хүнд хэцүү цаг үе байсан гэж ярьж байсан юм.

—Дараа нь яасан бэ? гэж тахийг асуухад,

—Бас адуу агнадаг хүмүүс ч байдаг байсан гэсэн. Тэгээд л аажим аажмаар бүх тахь алга болсон доо. Гэхдээ адуу агнахаа аль хэдийн больсон ч тахь байхгүй хэвээрээ байна. Одоо ч гэсэн. Би анх удаа л энд та нарыг олж харж байна. Та нар ч бас болгоомжтой байх

хэрэгтэй шүү, саяхан хүмүүс манай сүргийн нэг хуланг алчихсан гэж хэлээд яваад өгчихөв.

"За тэр, би та нарт үргэлж л хэлдэг биз дээ. Хүмүүсээс болгоомжлох хэрэгтэй" гэж тахийн хажууд зогсож байсан азарга хэлэв. Тахь бүр будилж, "Олон жилийн өмнө бидэн шиг адуу байж байгаад алга болчихсон гэнэ, яасан юм бол?" гэж бодлогошрон явтал замд нь шим шүүстэй бут өвс тааралдаж тэрээр өвөг дээдсийнхээ хувь тавиланг мартаж орхих нь тэр.

- **1960–аад оны сүүлчээр** хүмүүс гэрийн тэжээмэл адууны өвөг эцэг болох Пржевальскийн адууг Тахийн тал нутагт хамгийн сүүлд олж харсан байна. Үүнээс хойш тэдний зэрлэг байдал үгүй болж, тэд зөвхөн амьтны хүрээлэнд амьдран үлджээ.
- **1990 онд** анхны Пржевальскийн адууг Тахийн талд эргүүлэн авчирсан бөгөөд тэд бараг 30 жилийн дараа анх удаагаа эх нутагтайгаа эргэн золгожээ. Энэ хооронд энэ нутагт Говь – Б Улсын тусгай хамгаалалттай газар байгуулагдсан байна. Ингэснээрээ амьтны болон ургамлын баялаг ертөнцийг хамгаалах болсон юм.
- Ийнхүү **1997 онд** тахийн анхны сүрэг байгальд дахин чөлөөтэй амьдрах болсон билээ.

Одоогоор говьд зэрлэг байдлаар амьдарч байгаа Пржевальскийн хэдэн адуу байгаа ч тоо толгойн хувьд хангалттай биш юм. Монгол нутгийн соёлын нэгэн өв болсон Тахийг говь нутагт нь нутагшуулан амьдруулахад бид бүгдийн гар бие оролцох ёстой юм.

ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

Орчуулагч: С.Оюунтуяа
Редактор: Б.Сор-Тана